

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН БАТАЛСАН
ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын ерөнхий газар

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар)

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Бүртгэсэн огноо Дугаар	Үндэслэх		Захиргааны хэм хэмжээний актын		
			Хуулийн нэр	Хуулийн заалт	Үндэслэх хуулийн заалт, умга	Хэрэгжилт	Үнэлгээ
1	Журам батлах тухай 2023.10.24 А/139	2023.12.28 6519	Нийгмийн даатгалын ерөнхий хууль;	37.13.1	37.13.1."Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмж, чиглэл гаргах";	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Журам батлах тухай А/139 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын даргын 2024 оны 04/367 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100
	Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам;		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль;	20.7	20.7. “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална”;		
2	Журам батлах тухай 2023.12.27 А/190 Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх,	2024.02.16 6641	Нийгмийн даатгалын ерөнхий хууль;	20.5	20.5."Бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам, холбогдох маягтын загварыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Журам батлах тухай А/190 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам”-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын даргын 2024 оны 04/367 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100

	хөтлөх, шилжүүлэх журам;						
3	Журам батлах тухай 2023.12.28 А/194 “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”;	2024.02.16 6642	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль;	15.3	15.3.”Энэ хуулийн 15.1-д заасан өргөдлийн маягтын загвар, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам, тэтгэмж бодох аргачлал, зааврыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална”	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Журам батлах тухай А/194 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын даргын 2024 оны 04/367 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тус тушаалаар “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”-ыг нэгдүгээр, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг хоёрдугаар, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг гуравдугаар, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг дөрөвдүгээр, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг тавдугаар, “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим)”-ыг зургаадугаар, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цаасан)”-ыг долоодугаар, “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт”-ыг наймдугаар хавсралтаар тус тус баталсан. 2025 оны 4 дүгээр сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас 32.2 мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 15.5 тэрбум төгрөг, 17.4 даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 68.2 тэрбум төгрөг, 4.5 мянган нас барсан даатгуулагчийн ар гэрт 8.9 тэрбум төгрөг, нийтдээ 54.1 мянган даатгуулагчид 92.6 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна. ҮОМШӨ-ний даатгалын сангаас 516 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 947.6 сая төгрөг, 9 нас барсан даатгуулагчийн ар гэрт 18.0 сая төгрөгийн тэтгэмж тус тус олгосон байна.	100

						Ажилгүйдлийн даатгалын сангаас 9.9 мянган даатгуулагчид 60.1 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгов.	
4	Журам батлах тухай 2024.06.18 А/107 Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам;	2024.07.08 6885	Нийгмийн даатгалын ерөнхий хууль;	26.2 37.13.1	26.2."Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална" 37.13.1."Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмж, чиглэл гаргах";	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Журам батлах тухай" А/107 дугаар тушаалаар баталсан "Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох тухай журам"-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын даргын 2024 оны 07/1672 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлд 405.5 мянган төгрөгийг буцаан олгосон байна.	100
5	Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай 2024.12.26 А/246 Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам";	2025.01.06 7020	Нийгмийн даатгалын ерөнхий хууль; Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль;	37.13.1 22.4	37.13.1."Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тушаал, дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмж, чиглэл гаргах"; 22.4."Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох зааврыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална";	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай А/246 дугаар тушаалаар баталсан "Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам"-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/73 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тус тушаалаар "Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам"-ыг нэгдүгээр, "Тэтгэвэр бодох заавар"-ыг хоёрдугаар, "Өндөр насны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар"-ыг гуравдугаар, "Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар"-ыг тавдугаар, "Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох маягтын загвар"-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсан. 2025 оны 04 дүгээр сарын мэдээгээр тэтгэврийн даатгалын сангаас 408.5 мянган даатгуулагчийн өндөр насны тэтгэвэрт 1,451.9 тэрбум төгрөг, 61.1	100

						мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт 138.6 тэрбум төгрөг, 19.9 мянган даатгуулагчийн тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 46.8 тэрбум, 22.2 мянган цэргийн алба хаагчийн тэтгэвэрт 119.8 тэрбум нийт 511.7 тэтгэвэр авагчид 1,757.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгов. ҮОМШӨ-ний даатгалын сангаас 3.4 мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт 13.5 тэрбум төгрөг, 451 даатгуулагчийн тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1.7 тэрбум төгрөг олгов.	
НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ							100

--oOo--

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ШИНЖИЙГ АГУУЛААГҮЙ, ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЖТЭЙ ЭСХҮЛ АЧ ХОЛБОГДЛОО АЛДСАН, ДАГАЖ МӨРДӨГДӨХГҮЙ БОЛСОН ШИЙДВЭР БАЙГАА БОЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОН САНГААС ХАСУУЛАХ ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газар

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Бүртгэсэн огноо Дугаар	Үндэслэх хуулийн нэр, заалт, үтгэ	(Хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тайлбар
1	Журам батлах тухай 2022.04.27 А/72 Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Тэтгэмж тооцсон жагсаалтыг" хоёрдугаар хавсралтаар, тэтгэмж шилжүүлэх "Төлбөрийн хүсэлт"-ийг гуравдугаар, "Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт (цахим)"-ийг дөрөв, тавдугаар хавсралт;	2022.05.06 5822	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25.3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн "Журам батлах тухай" А/72 дугаар тушаалаар баталсан "Тэтгэмж тогтоолгоход шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Тушаал хүчингүй болгох тухай" А/09 дүгээр тушалаар хүчингүй болгож Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Хариу хүргүүлэх тухай" 01/161 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/194 дүгээр тушаалаар "Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталсан тул хасуулах саналтай байна.
2	Журам батлах тухай 2021.03.10 А/38 Эмнэлгийн хуудас олгох, хянах журам;	2021.03.10 5169	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25.2, 25.3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/38 дугаар тушаалаар баталсан "Эмнэлгийн хуудас олгох, хянах журам"-ыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн "Тушаал хүчингүй болгох тухай" А/04 дүгээр тушаалаар хүчингүй болгож Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Хариу хүргүүлэх тухай" 01/161 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 дугаар тушаалаар баталсан "Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам"-ыг шинэчлэн баталсан тул хасуулах саналтай байна.

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН УЛСЫН НЭГДСЭН САНД БҮРТГЭЛТЭЙ ШИЙДВЭРТ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ШИЙДВЭРТ ХӨДӨЛГӨӨН ХИЙСЭН ЖАГСААЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газар

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Бүртгэсэн огноо Дугаар	Үндэслэх хуулийн нэр, заалт, утга	Хэрэгжилт	Тайлбар
1					
2					
3					

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН УЛСЫН НЭГДСЭН САНД БҮРТГҮҮЛЭЭГҮЙ ШИЙДВЭР

Нийгмийн даатгалын ерөнхий газар

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Бүртгэсэн огноо Дугаар	Үндэслэх хуулийн нэр, заалт, утга	Хэрэгжилт	Үнэлгээ
1					
2					
3					

